



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/181

Хэрлэн сум

Мал амьтны сэг зэм устгал, орчны халдваргүйтгэлийн арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.13 дахь заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.3.1, 7.3.2, 7.3.3, 7.3.4, 7.3.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал амьтны сэг зэмээс хүн малын халдварт өвчин тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор сэг зэмийг цуглуулж устгах, орчны халдваргүйтгэл хийх ажлыг 2025 оны 04 дүгээр сарын 01-ээс 2025 оны 05 дугаар сарын 01-ийг хүртэл хугацаанд зохион байгуулсугай.

2. Мал, амьтны сэг зэм устгал, орчны халдваргүйтгэлийг мал амьтны эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох журам зааврын дагуу орон нутгийн байгууллага, малчид, иргэдийн оролцоотой зохион байгуулж, хүн хүч, шаардагдах зардал, тээврийн хэрэгслийн асуудлыг шийдвэрлэж ажиллахыг сумын Засаг дарга нарт даалгасугай.

3. Мал, амьтны сэг зэмийн устгал, орчны халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулахад шаардлагатай халдваргүйтгэлийн бодис, хамгаалах хувцас хэрэгсэл, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга (Н.Анхбаяр), Байгаль орчны газрын дарга (Б.Амгаланбат), Мал, амьтны сэг зэмийн устгал, орчны халдваргүйтгэлийн арга хэмжээнд ажилгүй иргэдийг татан оролцуулах, түр ажлын байраар хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч, төсөл хөтөлбөрийн хүрээнд ажлын хөлсийг холбогдох журмын дагуу олгохыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга (Э.Хонгорзул) нарт даалгасугай.

4. Дээрх арга хэмжээний хүрээнд сумдад хяналт тавин ажиллах онцгой комиссын гишүүдийн хуваарийг хавсралтаар баталсугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Өнөрцолмон)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ



Аймгийн Засаг даргын 2025 оны
04 дугаар сарын 07 ний өдрийн
А/187 дугаар захирамжийн хавсралт

ОНЦГОЙ КОМИССЫН ГИШҮҮДИЙН
СУМД ХАРИУЦАН АЖИЛЛАХ ХУВААРЬ

Д/Д	Сумдын нэр	Онцгой комиссын гишүүдийн нэрс	Албан тушаал
1	Галшар	Б.Амгаланбат	Байгаль орчны газрын дарга
2	Баянхутаг	Б.Өнөрцолмон	Аймгийн Засаг даргын орлогч
3	Баянмөнх	О.Баярлхагва	Тагнуулын хэлтсийн дарга
4	Дархан	Б.Золбоо	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
5	Дэлгэрхаан	А.Жаргалсайхан	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
6	Жаргалтхаан	Ж.Эрдэнэбат	Онцгой байдлын газрын дарга
7	Цэнхэрмандал	Ү.Энх-Ариунаа	Улаан загалмайн хорооны дарга
8	Өмнөдэлгэр	Ч.Баярцолмон	Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
9	Батширээт	Л.Цэнддорж	Цэргийн штабын дарга
10	Биндэр	Д.Дашнамжилмаа (үүрэг гүйцэтгэгч)	Эрүүл мэндийн газрын дарга
11	Баян-Адрага	Н.Анхбаяр	Мал эмнэлгийн газрын дарга
12	Дадал	Б.Түмэнжаргал	Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
13	Норовлин	Б.Бат-Эрдэнэ	Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга
14	Батноров	Д.Баярхүү	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
15	Баян-Овоо	Х.Уртнасан	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга
16	Мөрөн	Н.Үнэнбат	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
17	Хэрлэн	Д.Эрдэнэбаатар	Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын Захирагч
18	Бор-Өндөр	Э.Жавхлантөгс	Цагдаагийн газрын дарга



نکاح

فتمین

۹۴

پسندیدم

و

م. ا. س. کمالی

کتابخانه مسجد جامع